



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 28 өдөр

Дугаар

73

Улаанбаатар хот

Нийслэлийн оны шилдэг багш,
дасгалжуулагч, тамирчин, арга
зүйч шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйч шалгаруулах болзлын дагуу дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодоос шалгаруулан ирүүлсэн хүмүүсийн материал, ажлын үзүүлэлт, үр дүнг үнэлж дүгнэн Нийслэлийн 2017 оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйч нарыг сонгон шалгаруулсугай.

2. Нийслэлийн 2017 оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйчээр шалгарсан хүмүүсийг шагнах шагналын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд шаардагдах 3.700.000 /гурван сая долоон зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Шалгаруулалтын арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаад/ үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын
хорооны даргын 2017 оны дугаар тушаалын хавсралт
сарын 28-ны өдрийн



Нийслэлийн оны шилдэг багш,
дасгалжуулагч, тамирчин, арга
зүйч шалгаруулах төсөв

№	Зардлын нэр	Зардлын хэмжээ /төг/	Нийт зардал /төг/
1.	Тэргүүний багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйчийн шагнал	4x200.000	800.000
2.	Цом, өргөмжлөл	500.000	500.000
3.	Анонс, урилга	100.000	100.000
4.	Заал талбайн түрээс /үзель/ хөтлөгч	2000.000	2000.000
5.	Медаль, чимэглэл видео бичлэг	300.000	300.000
ДҮН:		3.700.000	3.700.000

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАСАН:

А.БОЛДМАА
О.ЭРДЭНЭЦЭЦЭГ